# НИЙТИЙН ТЭЭВРИЙН ГАЗАР

## ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭ ГАРГАЖ ИРҮҮЛЭХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ЗААЛТ /2022 оны жилийн эцэс/

2023 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр

| Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн явц |
|---|---|---|
| ЗГ-ын тогтоол | | |
| Нийслэл Улаанбаатар хотын талаар авах зарим арга хэмжээний тухай 2021-05-19 Дугаар 2021_146 | 2. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх гадаадын зээл, тусламжийн төсөл, арга хэмжээг холбогдох хууль тогтоомжийн дагуу Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхлан, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Үндэсний хөгжлийн газар (Х.Батжаргал) нарт даалгасугай. | Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах, нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр хэрэгжүүлэх гадаадын зээл, тусламжийн төсөл, арга хэмжээтэй холбоотой ажил байхгүй.<br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, "Сүлдэрхан минералс" ХХК болон "Xia men golden dragon bus" Co.,Ltd хооронд 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан "Зам, тээврийн хөгжийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт /Улаанбаатар/ Нийтийн тээврийн парк шинэчлэлт"-ийн НХААГ-21/015 дугаар гэрээний дагуу нийлүүлэгдэх олон улсын стандартын шаардлага хангасан Евро-5 хөдөлгүүртэй Бүгд Найрамдах Хятад Ард Улсад үйлдвэрлэсэн XIAMEN GOLDEN DRAGON BUS XML6105J15C загварын их багтаамжийн 60 автобусыг "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-т 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүлээлцүүлж нийтийн тээврийн үйлчилгээнд 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн үйлчилгээнд явж эхлээд байна.<br>Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас 2021 оны 6 дугаар сард 35 их багтаамжийн автобус, 2022 онд 10 ширхэг давхар автобус, 1 ширхэг их багтаамжийн нийт 46 цахилгаан хөдөлгүүртэй автобус авч нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллуулж байна.<br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар "Моннис Моторс" ХХК -тай байгуулсан 2022 оны НЗДТГ-20/А-463-2-01 дугаар гэрээний дагуу "Моннис моторс" ХХК-иас нийт 75 хүүхдийн сургуулийн автобус нийлүүлэхээс 2020 онд "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-т 5 ширхэг хүүхдийн сургуулийн автобус, 2022 онд хүүхдийн сургуулийн 20 ширхэг автобусыг "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-т 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдөр хүлээлцүүлэв. "Сургуулийн автобус" төслийн хүрээнд сургуулийн хүүхдийн 50 автобус 2023 оны 01 дүгээр сарын 11-нд Налайхад ирсэн бөгөөд хүлээн авахаар бэлтгэл ажлыг хангаж байна. "Сургуулийн автобус"-ны чиглэлийн төлөвлөлтийг боловсруулахаар холбогдох судалгаа тооцооллыг гарган Нийслэлийн Ерөнхий боловсролын газартай хамтран ажиллаж байна.<br>Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Xiamen Golden Dragon Bus" ХХК-тай их багтаамжийн евро дизель V хөдөлгүүр бүхий 224 автобус нийлүүлэх 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 03-01/01, 03-02/02 дугаартай гэрээг байгуулж, гэрээний дагуу 2023 оны 01 дүгээр сард 100, 2 дугаар сард 124 автобус хуваарийн дагуу нийлүүлэгдэхээр төлөвлөгдөөд бөгөөд Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-т 90 автобус, Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-т 27 автобусыг хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулж, 2023 оны 01 дүгээр |

| | | |
|---|---|---|
| | | сарын 16-ний өдрөөс эхний ээлжийн их багтаамжийн 30 автобусыг үйлчилгээнд гаргаад байна.<br>Мөн Нийслэлийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/900 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтаар Нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээний 7 ажлын жагсаалтыг баталсан. Дээрх ажлын зөвлөх үйлчилгээнд захиалагчийн хяналтыг Нийтийн Тээврийн газрын даргын 2022 оны А/61 дүгээр тушаалаар нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний судалгаа, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээний ажилд хяналт тавих ажлын хэсэг байгуулагдан 12 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж<br>1. “Шинэ төрлийн их багтаамжийн нийтийн тээврийн хэрэгслийн харьцуулсан судалгаа боловсруулах”<br>2. “Нийтийн тээврээр зорчих тасалбарын төлбөр болон нийтийн тээврийн салбарт олгодог санхүүжилт тэдгээрийн эдийн засгийн үр нөлөөллийн судалгаа боловсруулах"<br>3. “Тулгуурт гүүрэн байгууламж бүхий шинэ төрлийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх урьдчилсан ТЭЗҮ боловсруулах”<br>4. “Дүүжин тээврийн төслийн Баянхошуу-Ханын материал Гэмтлийн эмнэлэг чиглэлийн зорчигчийн нягтрал, ашиг алдагдлын тооцоо судалгаа боловсруулах”<br>5. “Нийтийн тээврийн чиглэл сайжруулалтын тооцоолол судалгаа боловсруулах” ажлууд хийгдсэн. |
| | 3. Энэ тогтоолын 1, 2-т заасан санхүүжилтийн эх үүсвэрийн хүрээнд Нийслэл Улаанбаатар хотын авто зам, замын өргөтгөл, шинэчлэл, зогсоол, уулзвар, нүхэн гарц, гүүрэн байгууламж, хурдны замын бүтээн байгуулалт, нийтийн тээврийн парк шинэчлэл зэрэг зам, тээвэр зохицуулалтын цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тооцож төлөвлөхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгасугай. | Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Сүлдэрхан минералс” ХХК болон “Xia men golden dragon bus” Co.,Ltd хооронд 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан “Зам, тээврийн хөгжийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт /Улаанбаатар/ Нийтийн тээврийн парк шинэчлэлт”-ийн НХААГ-21/015 дугаар гэрээний дагуу нийлүүлэгдэх олон улсын стандартын шаардлага хангасан Евро-5 хөдөлгүүртэй Бүгд Найрамдах Хятад Ард Улсад үйлдвэрлэсэн XIAMEN GOLDEN DRAGON BUS XML6105J15C загварын их багтаамжийн 60 автобусыг “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-т 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүлээлцүүлж нийтийн тээврийн үйлчилгээнд 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн үйлчилгээнд явж эхлээд байна.<br>Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ Хөгжлийн банкны зээлийн хөрөнгөөр Бүгд Найрамдах Хятад Ард Улсаас 2021 оны 6 дугаар сард 35 их багтаамжийн автобус, 2022 онд 10 ширхэг давхар автобус, 1 ширхэг их багтаамжийн нийт 46 цахилгаан хөдөлгүүртэй автобус авч нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллуулж байна.<br>Хотын түгжрэлийг бууруулах, сургуулийн хүүхдийн аяа тухтай, аюулгүй зорчих ажлын хүрээнд “Сургуулийн автобус” төслөөр “Моннис Моторс” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу сургуулийн хүүхдийн 50 автобус 2023 оны 01 дүгээр сарын 11-нд Налайхад ирсэн бөгөөд хүлээн авахаар бэлтгэл ажлыг хангаж байна.<br>Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Xiamen Golden Dragon Bus" ХХК-тай их багтаамжийн евро дизель V хөдөлгүүр бүхий 224 автобус нийлүүлэх 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 03-01/01, 03-02/02 дугаартай гэрээг байгуулж, гэрээний дагуу 2023 оны 01 дүгээр сард 100, 2 дугаар сард 124 автобус хуваарийн дагуу нийлүүлэгдэхээр төлөвлөгдөөд бөгөөд “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-т 90 автобус, “Зорчигч тээвэр |

| | | |
|---|---|---|
| | | гурав" ОНӨААТҮГ-т 27 автобусыг хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулж, 2023 оны 01 дүгээр сарын 16-ний өдрөөс эхний ээлжийн их багтаамжийн 30 автобусыг нийтийн тээврийн үйлчилгээнд гаргаад байна.<br>Нийслэлийн Засаг даргын 2022 оны 09 дүгээр сарын 06-ний өдрийн А/1155 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан Автобусны зогсоол барьж, тохижуулах ажил /ХУД 15, 17, 18 дугаар хороо/ төсөл, арга хэмжээний зөвхөн батлагдсан захирамжид тусгагдсан хороодод битүү, задгай автобусны зогсоол барьж, тохижуулах саналаа байршлын хамт 2022 оны 09 дүгээр сарын 19-ны өдөр 2/1118 дугаартай албан бичгээр Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт 6 ширхэг автобусны зогсоол тохижуулах саналаа хүргүүлсэн.<br>УИХ-ын гишүүн Ж.Сүхбаатар гишүүний санаачилгаар Зам тээврийн сайдын багцаар Чингэлтэй дүүргийн Хайлааст, Дэнжийн мянгын авто замд чиглэлийн тээврийн хэрэгслийн 19 зогсоолыг тохижуулахаар "Цагаан толгойн нуур" ХХК шалгарч 15 зогсоолыг хүлээн авсан.<br>Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/259 дүгээр захирамжаар 2022 онд Нийслэлийн гэр хорооллын нийтийн тээврийн үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдийн тав тухтай зорчих нөхцөлийг хангах үүднээс 6 эцсийн зогсоол, 36 дундын зогсоолыг тохижуулах 100 зогсоолын байршлыг тогтоож 36 дундын зогсоол дээр тендер зарлах ажил явагдаж байна. |
| | 4. Нийслэл Улаанбаатар хотод багтаамж ихтэй, шинэ төрлийн нийтийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх төсөл, арга хэмжээг судалж, боломжит эх үүсвэрийг тооцож төслийн ажлыг 2021 онд багтаан эхлүүлэхийг Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Сангийн сайд Б.Жавхлан, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г.Ёндон, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт зөвшөөрсүгэй. | Нийслэлийн Засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн А/900 дүгээр захирамжийн 2 дугаар хавсралтаар Нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээний 7 ажлын жагсаалтыг баталсан. Дээрх ажлын хүрээнд "Тулгуурт гүүрэн байгууламж бүхий шинэ төрлийн тээврийн хэрэгсэл нэвтрүүлэх урьдчилсан ТЭЗҮ" боловсруулах, "Нийтийн тээврээр зорчих тасалбарын төлбөр болон нийтийн тээврийн салбарт олгодог санхүүжилт тэдгээрийн эдийн засгийн үр нөлөөллийн судалгаа", "Дүүжин тээвэр төслийн Баянхошуу-Ханын материал Гэмтлийн эмнэлэг чиглэлийн зорчигчийн нягтрал, ашиг алдагдлын тооцоо судалгаа", "Шинэ төрлийн тээврийн хэрэгслийн харьцуулсан судалгаа боловсруулах ажлууд тус тус хийгдсэн. Нийтийн тээврийн салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний судалгаа, ТЭЗҮ, зөвлөх үйлчилгээний ажлын хүрээнд нийт 721.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Тулгуурт гүүрэн байгууламж бүхий хөнгөн галт тэрэгний төслийг Шинэ бүтээн байгуулалт ХХК хариуцан гүйцэтгэхээр болсонтой холбогдуулан мэдээлэл солилцож хамтран ажиллаж байна. |
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | | |
| 2022 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 31 дүгээр тэмдэглэл 2022-05-31 Дугаар 2022_31 | XXIII.2.4. Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн хүртээмж, үйлчилгээг сайжруулах зорилгоор нийтийн тээврийн парк шинэчлэлийн хүрээнд хийгдэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт. | Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, "Сүлдэрхан минералс" ХХК болон "Xia men golden dragon bus" Co.,Ltd хооронд 2021 оны 10 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан "Зам, тээврийн хөгжийн салбарын Улаанбаатар хотод хийгдэх хөрөнгө оруулалт /Улаанбаатар/ Нийтийн тээврийн парк шинэчлэлт"-ийн НХААГ-21/015 дугаар гэрээний дагуу нийлүүлэгдэх олон улсын стандартын шаардлага хангасан Евро-5 хөдөлгүүртэй Бүгд Найрамдах Хятад Ард Улсад үйлдвэрлэсэн XIAMEN GOLDEN DRAGON BUS XML6105J15C загварын их багтаамжийн 60 автобусыг "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-т 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдөр хүлээлцүүлж нийтийн тээврийн үйлчилгээнд 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн үйлчилгээнд явж эхлээд байна.<br>Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Xiamen Golden Dragon Bus" ХХК-тай их багтаамжийн евро дизель V хөдөлгүүр бүхий 224 автобус нийлүүлэх 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 03-01/01, 03-02/02 дугаартай гэрээг байгуулж, |

| | | |
|---|---|---|
| | | гэрээний дагуу 2023 оны 01 дүгээр сард 100, 2 дугаар сард 124 автобус хуваарийн дагуу нийлүүлэгдэхээр төлөвлөгдөөд бөгөөд "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-т 90 автобус, "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-т 27 автобусыг хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулж, 2023 оны 01 дүгээр сарын 16-ний өдрөөс эхний ээлжийн их багтаамжийн 30 автобусыг нийтийн тээврийн үйлчилгээнд гаргаад байна.<br>Хотын түгжрэлийг бууруулах, сургуулийн хүүхдийн ая тухтай, аюулгүй зорчих ажлын хүрээнд "Сургуулийн автобус" төслөөр "Моннис Моторс" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу сургуулийн хүүхдийн 50 автобус 2023 оны 01 дүгээр сарын 11-нд Налайхад ирсэн бөгөөд хүлээн авахаар бэлтгэл ажлыг хангаж байна. |
| 2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 Дугаар 2022_47 | IX.1.2. Нийслэлийн авто замын зорчих хэсэгт нийтийн тээврийн тусгайлсан эгнээ бий болгох, автобусны богино эргэлтийн чиглэл нэвтрүүлэх санал боловсруулж танилцуулахыг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Нийтийн тээврийн алслагдсан суурьшлын цэгүүдээс дараах 10 чиглэлийн 72 автобусыг богино эргэлтэд оруулан, төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд чиглэлийн давхцал буурах, давтамжийн тоо нэмэгдэх, хүлээх хугацаа богиносох, зорчилтод зарцуулах хугацаа багассан үр дүн гарсан. Улмаар нэмж 3 чиглэлийн 26 тээврийн хэрэгслийг богино эргүүлэх төлөвлөлтийг 2022 оны 10 дугаар 15-ны өдрөөс хэрэгжүүлсэн. Энхтайваны өргөн чөлөөний нэгдүгээр эгнээний захирамжийн хэрэгжилтийг хангуулах аяны хүрээнд Энхтайваны өргөн чөлөөний авто замын нэгдүгээр эгнээг чөлөөлснөөр төв зам дагуу үйлчилгээнд ажиллаж буй нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим дунджаар 8,6 км/цагаас 11,6 км/цаг болж өссөн үзүүлэлттэй байна.<br>Энхтайваны өргөн чөлөөний нэгдүгээр эгнээний захирамжийн хэрэгжилтийг хангуулах аяны хүрээнд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс 14 хоногийн хугацаанд Энхтайваны өргөн чөлөөний авто замын нэгдүгээр эгнээг чөлөөлснөөр төв зам дагуу үйлчилгээнд ажиллаж буй нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим дунджаар 8,6 км/цагаас 11,6 км/цаг болж өссөн үзүүлэлттэй байна. Чиглэлийн тээврийн хэрэгслүүд чөлөөтэй зорчих нөхцөлийг бүрдүүлэх, зорилгоор Нийтийн тээврийн газрын Автотээврийн хяналтын улсын 16 байцаагч нэгдүгээр эгнээ, автобусны буудал дээр зогссон тээврийн хэрэгслийн 59 зөрчлийг баримтжуулан E-Police аппликейшнаар Замын хөдөлгөөний удирдлагын төвд хүргүүлэн, 1475,0 мянган төгрөгийн торгуулийн хуудсыг гэрийн хаягаар хүргүүлсэн. |
| | IX.1.3. "Наадамчдын өргөн чөлөө", эсхүл "Энхтайваны өргөн чөлөө"-ний авто замд нийтийн тээврийн хэрэгслийн "зорчих хэсгийн тусгайлсан эгнээ"-г барьж байгуулах төслийг Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлд хамруулах санал боловсруулж Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Энхтайваны өргөн чөлөөний нэгдүгээр эгнээний захирамжийн хэрэгжилтийг хангуулах аяны хүрээнд 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрөөс 14 хоногийн хугацаанд Энхтайваны өргөн чөлөөний авто замын нэгдүгээр эгнээг чөлөөлснөөр төв зам дагуу үйлчилгээнд ажиллаж буй нийтийн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим дунджаар 8,6 км/цагаас 11,6 км/цаг болж өссөн үзүүлэлттэй байна. Наадамчдын замаар чиглэлийн тээврийн хэрэгслийг нэгдүгээр эгнээгээр зорчуулах талаар Нийслэлийн засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн хуралдааны тэмдэглэлээр холбогдох мэргэжлийн байгууллагуудад бэлтгэл ажлыг хангуулах үүрэг чиглэл өгөгдөж экспрес чиглэлийн төлөвлөлтийг боловсруулсан. |
| | IX.1.4. "Car pooling service" буюу автомашин хуваалцах үйлчилгээний талаар судалж, нэвтрүүлэх арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч | "Car pooling service" буюу автомашин хуваалцах үйлчилгээний талаар хийгдсэн ажил байхгүй. |

| | | |
|---|---|---|
| | Д.Сумъяабазар нарт; | |
| | IX.1.16. Нийтийн тээврийн автобусны тоог нэмэгдүүлэх, автобусны терминал, бааз байгуулах ажлыг эрчимжүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Xiamen Golden Dragon Bus" ХХК-тай их багтаамжийн евро дизель V хөдөлгүүр бүхий 224 автобус нийлүүлэх 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 03-01/01, 03-02/02 дугаартай гэрээг байгуулж, гэрээний дагуу 2023 оны 01 дүгээр сард 100, 2 дугаар сард 124 автобус хуваарийн дагуу нийлүүлэгдэхээр төлөвлөгдөөд бөгөөд “Зорчигч тээврийн нэгтгэл” ОНӨААТҮГ-т 90 автобус, “Зорчигч тээвэр гурав” ОНӨААТҮГ-т 27 автобусыг хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулж, 2023 оны 01 дүгээр сарын 16-ний өдрөөс эхний ээлжийн их багтаамжийн 30 автобусыг нийтийн тээврийн үйлчилгээнд гаргаад байна.<br>Хотын түгжрэлийг бууруулах, сургуулийн хүүхдийн ая тухтай, аюулгүй зорчих ажлын хүрээнд “Сургуулийн автобус” төслөөр “Моннис Моторс” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу сургуулийн хүүхдийн 50 автобус 2023 оны 01 дүгээр сарын 11-нд Налайхад ирсэн бөгөөд хүлээн авахаар бэлтгэл ажлыг хангаж байна.<br>Нийслэлийн иргэдийн ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулах бэлтгэл ажлын хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр “Нийтийн тээврийн үйлчилгээнд эрс шинэчлэлт хийх” талаар танилцуулга бэлтгэн, богино эргэлтийн чиглэлүүдийн төлөвлөлтийг хэрэгжүүлэхэд зорчигчдын дамжин суултын 7 терминал болон автобус буцаж эргэх авто замын зохион байгуулалтыг хийх шаардлагатай саналыг НЗД-ын ахлах зөвлөх Д.Мөнх-Эрдэнэд, мөн 2022 оны 10 дугаар сарын 08-ны өдөр Засгийн газар, Улсын их хурлын гишүүдтэй хийх уулзалтын үеэр богино эргэлт хийх чиглэлүүдийн дамжин суулт хийх терминал байгуулах шаардлагатай талаар тус тус танилцуулсан. Улаанбаатар хотын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээний богино эргэлтийн чиглэлүүдийн төлөвлөлтийг боловсруулан ажиллаж байгаа бөгөөд чиглэлийн тээврийн хэрэгсэл эргэхэд зориулагдсан терминал байгуулах байршлын саналыг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн 2/1290 тоот албан бичгээр Нийслэлийн газар зохион байгуулалтын албанд хүргүүлсэн. |
| | IX.1.17. Нийтийн тээврийн салбарын удирдлага, зохион байгуулалт, менежментийг өөрчлөх, шинэчлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт; | Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Б/127 дугаар захирамжаар С.Жавхлантбаатарыг Нийтийн тээврийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон. Нийтийн тээврийн газрын удирдлага, зохион байгуулалт, менежментийг өөрчлөх, шинэчлэх зорилгоор бүтэц зохион байгуулалтын судалгаа хийгдэж байна.<br>Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилтын хүрээнд нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, стандартыг мөрдүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг шинэ түвшинд хүргэх, нийтийн тээврийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг оновчтой, үр ашигтай зохион байгуулах чиглэлээр санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсэг хуралдаж хийгдэх ажлын төлөвлөгөөний саналыг боловсруулж Нийслэлийн засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. |
| 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл | XII.6. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, | Хотын түгжрэлийг бууруулах, сургуулийн хүүхдийн ая тухтай, аюулгүй зорчих ажлын хүрээнд “Сургуулийн автобус” төслөөр “Моннис Моторс” ХХК-тай байгуулсан гэрээний дагуу сургуулийн хүүхдийн 50 автобус 2023 оны 01 дүгээр сарын 11-нд Налайхад ирсэн бөгөөд хүлээн авахаар бэлтгэл ажлыг хангаж байна. |

| | | |
|---|---|---|
| 2022-10-10<br>Дугаар 2022_49 | нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар нарт даалгав: 1. Нийслэл Улаанбаатар хотын нийтийн тээврийн парк шинэчлэлтийг хийж, чанар, хүртээмжийг эрс сайжруулах, үйлчилгээний стандартыг тогтоох, нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийг шинэчлэн төлөвлөж, хэрэгжилтийг хангах; 2. Нийтийн тээврийн удирдлага, зохион байгуулалт, тулгамдсан бусад асуудлыг шийдвэрлэх ажлын төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх, ажлын явц байдлыг Засгийн газарт танилцуулж ажиллах; | Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын "Xiamen Golden Dragon Bus" ХХК-тай их багтаамжийн евро дизель V хөдөлгүүр бүхий 224 автобус нийлүүлэх 2022 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 03-01/01, 03-02/02 дугаартай гэрээг байгуулж, гэрээний дагуу 2023 оны 01 дүгээр сард 100, 2 дугаар сард 124 автобус хуваарийн дагуу нийлүүлэгдэхээр төлөвлөгдөөд бөгөөд "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ-т 90 автобус, "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-т 27 автобусыг хүлээлцүүлэх ажлыг зохион байгуулж, 2023 оны 01 дүгээр сарын 16-ний өдрөөс эхний ээлжийн их багтаамжийн 30 автобусыг нийтийн тээврийн үйлчилгээнд гаргаад байна.<br>2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар нийтийн тээврийн үйлчилгээний 105 чиглэлээс богино эргэлтийн 27 чиглэл байна. 2020-2022 онуудад Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, автобус хоорондын хүлээгдлийн хугацааг багасгах зорилгоор алслагдсан суурьшлын цэгүүдээс дараах 10 чиглэлийн 72 автобусыг богино эргэлтэд оруулан, төлөвлөлтийг хэрэгжүүлсэн.<br>Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн Б/127 дугаар захирамжаар С.Жавхлантбаатарыг Нийтийн тээврийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон. Нийтийн тээврийн газрын удирдлага, зохион байгуулалт, менежментийг өөрчлөх, шинэчлэх зорилгоор бүтэц зохион байгуулалтын судалгаа хийгдэж байна.<br>Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилтын хүрээнд нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх, хүртээмжийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, стандартыг мөрдүүлэх, удирдлага, зохион байгуулалтыг шинэ түвшинд хүргэх, нийтийн тээврийн салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийг оновчтой, үр ашигтай зохион байгуулах чиглэлээр санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Тус ажлын хэсгийн хийгдэх ажлын төлөвлөгөөний саналыг боловсруулж Нийслэлийн засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн хүрээнд орж ирсэн 30 автобусыг Зорчигч тээврийн нэгтгэлийн нэгдүгээр баазын үйлчилгээ үзүүлдэг 6 чиглэлд явуулахаар төлөвлөлтийг боловсруулж 2023 оны 01 дүгээр 16-ний өдрөөс үйлчилгээг эхлүүлсэн. Ингэснээр тус байгууллагын ажлын өдрийн гаралт 26 хувиар, амралтын өдрийн гаралт 37 хувиар шинэчлэгдэхээр байна. |

ТАНИЛЦСАН:
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ С.ЖАВХЛАНТБААТАР

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.БОЛОРЦЭЦЭГ